

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022.12.08

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус тус тусгагдсан зорилт, арга хэмжээ, "Хүний хөгжлийг дэмжих жил"-д зориулан эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулах, иргэдийн оролцоог дэмжин соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг иргэд, олон нийт, албан хаагч, аж ахуйн нэгж, байгууллагад хүртээмжтэй хэлбэрээр хүргэж, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар, сумдад бэлтгэгдсэн "Эрх зүйн хөтөч"-үүд, сумдын орон тооны бус "Эрх зүйн хөтөч" багийн ахлагч буюу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, сурталчлан таниулах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн хариу өгөх, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулан 2022 онд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт, бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид цахим болон гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар

Тайлант хугацаанд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 511 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс шинээр 41, нэмэлт өөрчлөлт орсон 398 хууль, Засгийн газрын тогтоол 30, УИХ-ын тогтоол 40, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 2-ийг тус тус бүртгэн санг баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт давхардсан тоогоор 12 хууль, хүчингүй болсон хасагдсан 83 зүйл, заалтыг тухай бүр эрх зүйн ангилал хийж, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 95 иргэн, албан тушаалтанд үзүүлж үйлчилгээг хүргэлээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж санал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 370 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулж санал авах ажлыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 388 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтны эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, зарим шийдвэрийг байгууллага, иргэдэд хуулбар хувиар хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас "Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай", "Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр төлбөрийн хэмжээг тогтоох тухай", Гурвансайхан, Сайхан-Овоо, Өндөршил сумдын "Малын тоо

толгойд 2022 онд ногдуулах албан татварын хэмжээ тогтоох тухай журам”, Дэлгэрцогт сумын “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай журам”-уудыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулахаар www.dundgovi.gov.mn цахим хаягаар иргэдээс санал, хүсэлтийг хүлээн авч төсөлд тусган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаар “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих журам”-ын төслийг хэлэлцүүлэн баталж улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан санд бүртгэгдээгүй хүлээгдэж байна.

“Бүрдийн уянга зусланд амрагчдын үнэ тарифыг шинэчлэн батлах тухай”, “Хүүхдийн парк”-аар үйлчлүүлэгчдийн эрхийн бичгийн үнийг шинэчлэн тогтоох тухай журам”-уудыг бүртгүүлэхээр хүргүүлсэн боловч тухайн хуралд тусгайлсан эрх олгогдоогүй шалтгаанаар дүгнэлт ирүүлсний үндсэн дээр тухай тогтоолыг хүчингүй болгосон.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж
буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг
арилгуулах талаар авсан арга хэмжээ

Сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа.

2022 онд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан 1341 эрх зүйн акт, сумдын төрийн байгууллагуудын дарга нараас батлан гаргасан 974 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан 1121 тушаалыг хуваарийн дагуу хянаж, зөрчилтэй 613 захирамж, тушаал буюу 17.8 хувьд нь гаргасан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлсэн.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж
буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг
зохион байгуулж, санал авсан талаар

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын шийдвэрээр 2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг танхимаар зохион байгуулан, эрх зүйн сургалтыг 14 удаа 840 хүнд, сурталчилгаа, хэлэлцүүлгийг 3 удаа 541 хүнд тус тус зохион байгууллаа. “Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар”, “Дундговь Эрх зүйн хөтөч”, “Сумдын эрх зүйн хөтөч” “Дундговь Насан туршийн боловсрол”, “Авлигагүй Дундговь” пэйж хуудсуудаар иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сурталчилгаат үйл ажиллагаануудыг зохион байгуулан, аймаг, сумын эрх зүйн хөтөчүүд хамтран цахимаар болон танхимын хэлбэрээр эрх зүйн сургалтыг 131 удаа, 7545 хүнд буюу 16-аас дээш насны иргэдийн 23.5 хувьд нь зохион байгуулж, 146 нийтлэлийг байршуулан



иргэд, олон нийтэд хүргэж, хууль, эрх зүйн туслалцаа хүссэн 300 хүнд Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийн хамт хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

➤ “Хүний хөгжлийг дэмжих жил”-д зориулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд сумдад бэлтгэгдсэн “Эрх зүйн хөтөч” нарыг давтан сургах тус оны эрх зүйн сургалтыг танхимын хэлбэрээр 2 өдөр зохион байгуулан, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэн чадавхжуулж, иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох зорилтыг тавин ажиллалаа. Уг сургалтад аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Сумын мэргэжилтний багийн ахлагч” нарыг оролцуулж, тэдний эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлж, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах ерөнхий чиг үүргээр хангаж, тусгайлсан сургалт, хэлэлцүүлэгийг хамт зохион байгуулав.



➤ Дээрх жилд зориулан сум, багийн удирдлагуудад шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль болон Захиргааны актад тавигдах шаардлага, анхаарах асуудлыг сурталчлан таниулах зорилго тавьж сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нарт давтан сургалтыг зохион байгууллаа.



➤ Багийн Засаг дарга нар, Сайнцагаан сумын ЗДТГ-ын албан хаагчид, тус сумдын харьяа төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнууд болох ЕБС-ийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлага, бизнес эрхлэгч, татвар төлөгч зэрэг 230 хүнд шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулиар эрх зүйн сургалтыг хийж, тэдэнд “Хөдөлмөрийн гэрээ”, “Туслах малчинтай байгуулах” гэрээнүүдийн загварыг тайлбарлан, хэлэлцүүлэг зохион байгуулж, гэрээг хүн бүрт түгээж тараалаа.

➤ Аймгийн ГХУСАЗСЗ-хөтөч нарын дунд тэдний үйл олон нийтийн эрх зүйн дээшлүүлэх, багаар уралдаан зарлан, иргэд, олгох чиглэлээр “Малчдын “Хууль тогтоомж сурталчлах” сэргийлэх ажлыг сум бүрт”



тэй хамтран сумдын Эрх зүйн ажиллагааг тогтмолжуулах, иргэд, боловсролыг тасралтгүй ажиллуулах зорилготой болзолт малчдад эрх зүйн боловсрол зөвлөгөө, “Малчны нэг өдөр” өдөрлөг, “Гэмт хэргээс урьдчилан зэрэг арга хэмжээнүүдийг

➤ Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын албан хаагчдад Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Захиргааны актад тавигдах шаардлага, анхаарах асуудал, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл тайлбар гаргах, Мэдүүлгийн төрөл, эрх зүйн зохицуулалт зэрэг сэдвүүдээр Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын болон түүний харьяа төрийн байгууллагуудын албан хаагчид, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн аймаг, сумдын улсын байцаагчид, Боловсрол шинжлэх ухааны газрын

A large, well-lit classroom with students in red and white uniforms seated at their desks. A teacher in a brown jacket and white mask is in the foreground, writing in a notebook. A presentation screen on the right displays the text "ПЕРВЫЕ ПОСЛЕДЫ" (First Consequences). The room has a wooden floor, white walls, and a large window.

ЕБС-ийн Цахилгаан

[illegible][illegible]

хөтөч”
даргын
хууль,


ажлыг

➤ “Хуульчийн Про боно” өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Мандал” худалдааны төв талбайд зохион өдөрлөгийг аймгийн Засаг дарга болон хууль хяналтын байгууллагуудын удирдлагууд нээж үг хэлсэн. Өдөрлөгт даргын Тамгын газар, Монголын холбооны аймгийн салбар, Хүний эрхийн комиссын аймаг дахь салбар, Хууль зүйн төв, аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн алба, аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөл, Нотиаратын танхим, Хууль, эрх зүйн Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг хууль хяналтын төрийн 18 байгууллага оролцож, “Хууль зүйн мэдээлэл үнэ төлбөргүй өгөх”, төрийн байгууллагууд “Төрийн байгууллагын зарим үнэ төлбөргүй үзүүлэх, иргэдийн гомдол хүлээн авч шийдвэрлэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргэх” зорилготой ажилласаны үр дүнд 430 олон нийтэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ мэдээ мэдээллийг хүргэн ажилласан.

➤ Хууль зүйн үндэсний бэлтгэн ирүүлсэн иргэдийн эрх зүйн дээшлүүлэх зорилготой бэлтгэсэн Цогоо, Ариун эрхэм нандин, Чимээгүй хөрш зэрэг 6 ширхэг киног www.dundgovi.gov.mn аймгийн Засаг даргын Тамгын сумдын “Эрх зүйн хөтөч” пэйж байгууллагуудын вэбсайт болон аймгийн төвд байрлаж буй ЛЕД сурталчлан таниуллаа.



байгуулан, уг Ц.Мөнхбат зарим аймгийн Засаг Хуульчдын үндэсний туслалцааны газар, Шүүхийн шинжилгээний аймгийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг хууль хяналтын төрийн 18 байгууллага оролцож, “Хууль зүйн мэдээлэл үнэ төлбөргүй өгөх”, төрийн байгууллагууд “Төрийн байгууллагын зарим үнэ төлбөргүй үзүүлэх, иргэдийн гомдол хүлээн авч шийдвэрлэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргэх” зорилготой ажилласаны үр дүнд 430 олон нийтэд хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ мэдээ мэдээллийг хүргэн ажилласан.



хүрээлэнгээс мэдлэгийг Надад итгэ, Гэнэн Дуудлага, Хүү, богино хэмжээний вэбсайт, “Дундговь газар”, аймаг, хуудас, сум, пэйж хуудас, дэлгэцээр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйл буюу аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд 2022 онд 147.585.600 сая төгрөг батлуулж, хууль сахиулах байгууллагуудын саналд үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн анхдугаар хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 40 заалттайгаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн танилцуулгыг хүргүүлж “Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг” уралдаан, “Хүүхэд хамгаалал” арга хэмжээ, “Өсвөрийн сэргийлэгч” тусгай арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс бүлгэмийн гишүүдийг энгэрийн тэмдэгтэй болгох, олон нийтийн

цагдаагийн урамшуулал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмж, нэгдсэн болон хэсэгчилсэн 27 арга хэмжээ зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлж зарцуулсан.

Энэ оны 11 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 11 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 21.4 хувиар буурсан ба хэргийн илрүүлэлт 36.4 хувьтай байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн 5 сумдын малчдыг хамруулан малчдын зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, Мал эмнэлгийн алба хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд 1 удаагийн сургалт, 8 суманд зохион байгуулагдсан “Малчдын өдөр” өдөрлөгт 8 удаагийн яриа таниулга хийж нийт 3800 малчин иргэд, төрийн алба хаагчдыг хамруулсан.

Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр “Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод”, “Та бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж аюулгүй зорчих”, “Хамгаалах бүсээ бүслэх гурван секунд таны ирээдүйн амьдралын баталгаа”, “Жолооны ард утсаар бүү оролд бүү ярь”, “Таны хурд хэтрүүлсэн хором мөч бүхэн хэн нэгний амьдралыг орвонгоор нь өөрчлөхөд бэлэн байдаг” гэх зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас шийдвэрлэн тарааж ажилласан.

Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах, аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон гэрэл Цагаан шугам 2022” тэмцээнийг аймгийн Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран амжилттай зохион байгуулсан.

Цагдаагийн газраас 2022 оны 11 сарын байдлаар нийт 19,897 зөрчилд 823,990,0 төгрөгний торгууль ногдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Эдгээр зохион байгуулсан ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 2022 оны 11 сарын байдлаар хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 7,9 хувь, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 46,7 хувиар өссөн, автотээврийн хулгай 60 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 21,4 хувь, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 50 хувь, бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг 34,6, гэмт хэрэгт холбогдсон хүн 12,8 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтэй байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр

“Архигүй амьдралыг цогцлооё-Архигүй төрийн алба” аяны хүрээнд “Архи, согтууруулах ундааны нийгэм, гэр бүлд үзүүлэх хор нөлөө” сэдвээр сургалт мэдээлэл хийж, 1 удаагийн подкаст нэвтрүүлэг, 14 төрлийн зурагт хуудас, 2 төрлийн теле зохиомж бэлтгэн, иргэд олон нийтэд хүргэсэн.

Архинд донтох өвчтэй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон 4 иргэнийг шүүхийн шийдвэр гаргуулан, архины албадан эмчилгээнд хамруулсан. Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрийн байгууллагад сургалт мэдээлэл хийж, хорт зуршлын хэрэглээнээс татгалзах уриалга, хор холбогдлыг харуулсан 8 төрлийн зурагт хуудас, сэрэмжлүүлгийг хувилж олшруулан 1500 иргэнд тарааж сурталчилсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хууль эрх зүйн хэлтэс хамтран “Гэмт хэргээс урьдчилан ажлыг сум бүрд” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулан 9 сумын 1450 иргэнд “Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ” сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн.

Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан архинд донтох өвчнийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүлэг,

нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллахаар аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжаар “Мэргэжилтний баг” байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, үйл ажиллагааг идэвхжүүлэхээр Сайнцагаан сумын “Говийн хийморь” АА бүлгийн 9 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэж, бүлгийн гишүүдийн уулзалт ярилцлага, “Гэгээн үдэш” цэнгүүн зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/95 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Сумын мэргэжилтний багийн ахлагч нар”-ыг чадавхжуулж, иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах ерөнхий чиг үүргээр хангаж, тусгайлсан сургалтыг зохион байгуулсан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Намайг алгас” нэгдсэн арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Тус аймгийн архивын тасгаас 2022 онд баримтын бүрдүүлэлт хийх 21 хөмрөг үүсгэгчийн баримт хүлээн авах арга зүйн зөвлөмж өгч ажилласанаар хөмрөгийн 744 хадгаламжийн нэгжийг архивт баримт хүлээн авч, бүртгэл, актыг зааврын дагуу хөтөлж, хөмрөгт байрлуулсан.

Шинээр ашиглалтанд оруулсан 37 барилгын засвар, өргөтгөлийн үйл ажиллагаанд улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, 150 хадгаламжийн нэгжийг зохих журмын дагуу хүлээн авч акт, жагсаалтыг үйлдэн зураг төсөл техник технологийн цаасан болон тусгай төрлийн баримтаар тус тус архивт баримт бүрдүүлэлт хийсэн.



Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 4 удаа хуралдуулж архивт баримт бүрдүүлэлт хийх сум, байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт зэрэг нийт 14 сум, байгууллагуудын бүртгэл жагсаалтыг хянан хэлэлцэж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв.

Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах ажлын хүрээнд <https://e-archives.gov.mn-ээп> тус онд нийт 121 хүсэлтийг хүлээн авч холбогдох лавлагааг тоон гарын үсгээр гаргаж онлайнаар хүргүүлсэн.

Баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 150 ширхэг хайрцаг захиалан авч 3 хөмрөгийн 4 дансны 245 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын хайрцагт хийж, заагуурыг шинэчлэв.

Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд 25 хөмрөгийн 36 дансны 700 хадгаламжийн нэгжийг цахимжуулахаар төлөвлөж ажилласнаар тус оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 29 хөмрөгийн удирдлагын баримтаас 621 хадгаламжийн нэгж баримт, нийт баримтаас 147 хадгаламжийн нэгж баримтыг <https://e-document.gov.mn> буюу цахим санд оруулаад байна.


Архивын газрын даргын 2021 оны А/25 дугаар батлагдсан “Архивын баримтыг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах нийтлэх журам”-ыг мөрдөн ажиллаж архивын баримтыг ашиглуулах зорилгоор иргэд, байгууллагын нийгэм эрх зүйн шинж чанартай лавлагаа олгох ажлыг хийж гүйцэтгэснээр нийт 1131 хүсэлтийг хүлээн авч 260 иргэнд лавлагаа, 750 хүн, хуулийн этгээдэд хувь хуулбар гарган өгч гаргаж үйлчилсэн. Эдгээр лавлагаанд давхардсан тоогоор 4080 гаруй хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагааны ажилд ашиглууллаа.



Уншлагын танхимаар үйлчлүүлсэн 4 иргэнд 111 хадгаламжийн нэгжийг судалгаанд ашиглуулсан.

МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвтэй хамтран архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтад 5, мэргэшүүлэхийн сургалтад 8, нийт 13 албан хэрэг хөтлөлтийн ажилтныг хамруулан сургалаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн Засгийн газрын 2021 оны 246 дугаар Улсын баримт бичгийн 2021 оны бичгээр үйлдэх баримт бичгийн түүний бүрдэлд тавих үндсэн оны стандарт зэргээр сургалт зохион сум, байгууллагын 543 албан хаагчдыг удаагийн онлайн сургалтыг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарт зохион байгуулсан. Үүнд нийт давхардсан тоогоор 30 сумын 65 албан хаагч хамрагдсан.



тухай хууль, тогтоол, Монгол стандарт, Монгол хэвлэмэл хуудас, шаардлага 2022 байгуулж нийт 75 хамруулсан. Мөн 3

2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр сум, байгууллагын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга нар, агентлагуудын дарга нарт “Архивын баримтыг анхан шатнаас зөв үйлдэх арга зүй” сэдвээр сургалт зохион байгуулж, тус сургалтад нийт 105 удирдах албан хаагч хамрагдсан.



Архивын ерөнхий газар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулсан Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага стандартын талаарх онлайн сургалтад сум, байгууллагын бичиг хэргийн ажилтан нарыг хамруулсан. Мөн тус оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран байгууллагын бичиг хэргийн ажилтан болон хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нийт 68 албан хаагчдад Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүйн сургалтыг зохион байгуулсан.



Архивын тасгийн үйл ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор тус тасагт тоног төхөөрөмжийн хангалт болон баримтын хадгалалт хамгаалалт, хадгаламжийн сангийн аюулгүй байдалд зориулж нийт 19.0 сая төгрөгний дэмжлэг үзүүллээ. Тус ажлын хүрээнд баримт хадгалах зориулалтын 16 ширхэг нягтруулсан шүүгээ, хадгаламжийн 2 санд хяналтын агааржуулалтын систем, тусгай хадгалах шүүгээ зэргээр ханган, хамгаалалтын нөхцөлийг



камер, хурдны скайнер, төрлийн баримт баримтын хадгалалт сайжруулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх хүрээнд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллалаа. Үүнд:

Цагдаагийн газрын үйл ажиллагаанд чанарын менежмент ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх, баталгаажуулалтын аудитын зардалд зориулан 3 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэрлэсэн.

Цагдаагийн газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор энгэрийн камер 7, хэт богино долгионы радио холбоо 6, мөн богино долгионы радио холбооны нөөц тэжээл 20 ширхэг зэрэг 12.700.000 төгрөгийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл шийдвэрлүүлсэн. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүсэлт хүргүүлж, 7,0 сая төгрөгийн өртөг бүхий дахин дамжуулах станц шийдвэрлүүлсэн.

Цагдаагийн газарт Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1 га газрыг шийдвэрлэн өгч төмс, хүнсний ногоо, жимсний мод тариалуулсан. Цагдаагийн газрын насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөний засвар, тохижилтын ажилд 5.0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Эрүүлжүүлэх баривчлах байрны агааржуулах төхөөрөмжний 2.3 сая төгрөгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлсэн.

Шүүхийн шинжилгээний албанд 6.9 сая төгрөгний үнэ өртөг бүхий компьютер, 3 үйлдэлт хэвлэгч машин, зургийн аппарат тус бүр нэг, зөөврийн моторыг тус тус шийдвэрлэж техник, тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хэрэгцээнд 3,9 сая төгрөгний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн ба аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн “Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай” А/375 дугаар захирамжаар 3284м2, 1493м2 газрыг албан хаагчдын орон сууцны барилгын газар олгосон.

Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хууль, хяналтын байгууллагуудын алба хаагчдын орон байрны дэмжлэгт зориулан Цагдаагийн газрын цагдаа жолооч Д.Чимэддоржид 7.0 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ш.Чулуун, Ё.Батбаяр нарт тус бүр 10.0 сая төгрөгийг нийт 27.0 сая төгрөгний дэмжлэг үзүүллээ. Мөн цэрэгжсэн байгууллагуудын хүсэлтийн дагуу Сүлд дурсгалын талбайн газрын асуудлыг шийдвэрлэсэн.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай

хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын аймаг дахь салбартай хамтран тус онд 18 удаа, 615 иргэнд хүний эрхийн талаарх эрх зүйн сургалтыг зохион байгуулж, Хүний эрхийн олон улсын өдрөөр “Центвар”, “Эрхээ мэдье” сурталчилгаат арга хэмжээг иргэдийн дунд зохион байгууллаа. Хүний эрхийн асуудлаар нийтдээ 52 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүллээ. Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 8 газар буюу Цагдаагийн газрын саатуулах, эрүүлжүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих, баривчлах байр болон аймгийн төвийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургууль, хөдөөгийн сумд болох Өндөршил, Гурвансайхан, Хулд, Луус зэрэг сумдын дотуур байруудад хяналт шалгалт зохион байгууллаа.

Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжин, иргэдэд үйлчилгээ үзүүлэх өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчин бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцаж хэвийн ажиллуулсан. Хууль зүйн туслалцааны төвийн аймаг дахь салбар зөвлөл нь төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгч нарт өмгөөллийн үйлчилгээг Дундговь аймгийн Цагдаагийн газрын Хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалт, Прокурор, Шүүхийн шатанд 49 хэргийн 54 хүн(холбогдогч)-ий хууль ёсны эрх ашгийг хамгаалан өмгөөлөгчөөр оролцсон. Анхан шатны шүүхэд 39 хэргийн 40 хүн(холбогдогч)-ий хэрэг маргааныг шийдвэрлэж, хууль зүйн анхан шатны зөвлөгөөг 300 хүнд үзүүлж, өргөдөл, гомдол нэхэмжлэлийн эх гаргаж зөвлөгөө өгч ажиллалаа.

“Таныг сонсьё-танд тусалъя”, “Өмгөөлөгч танд тусалъя”, “Хуульчийн Про Боно-2022” өдөрлөгүүдийг аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг, өмгөөлөгч нартай хамтран зохион байгуулж, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч, иргэд, олон нийтэд Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг сурталчиллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

/С.ЦЭНГЭЛМАА/

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

/Л.БАЯРСАЙХАН/

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2022 ОНЫ
ЖИЛИЙН АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл” сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	511	511
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо			511	511
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	5	5
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	481	481
		Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	884	95	979
			Байгууллага	35	36	71
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	415	300	715
			Байгууллага	35	30	65
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		1341	498	1839
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн	4	5	9
			Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-	2	2
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		117	14	131
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		6705	840	7545
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		174	3	177
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		35төрөл/3335	4 төрөл/600	39төрөл/3935
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг		52	14	66
		Сонин хэвлэлээр сурталчилсан		5	2	7
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан		1200	20	1220

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.ЦЭНГЭЛМАА/

МЭДЭЭГ ХЯНАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА /Л.БАЯРСАЙХАН/